



ДААТГУУЛАГЧИЙГ УРАМШУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ УРИЛГА

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт “Дараалсан гурван жилийн хугацаанд эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ аваагүй даатгуулагчийг нэг удаа эрүүл мэндийн бүрэн үзлэгт хамруулж урамшуулах...” гэж заасныг хэрэгжүүлэх ажлын хүрээнд даатгуулагчдад урамшууллын тусламж, үйлчилгээ үзүүлэх, хамтран ажиллах өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудыг урьж байна.

Урамшууллын үйлчилгээ үзүүлж, хамтран ажиллах хүсэлтэй эрүүл мэндийн байгууллагууд 2014 оны 08 дугаар сарын 01-ний дотор холбогдох материалаа бүрдүүлж, Нийгмийн даатгалын Ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын газарт биеэр болон шуудангаар ирүүлнэ үү.

Дэлгэрэнгүй мэдээллийг [энд дарж](#) авна уу.

Бүрдүүлсэн материалыг ирүүлэх хаяг:

Улаанбаатар хот-15160, Чингэлтэй дүүрэг, Хуульчдын гудамж 13/1, Нийгмийн даатгалын ерөнхий газрын байр, Эрүүл мэндийн даатгалын газрын 204, 602 тоот өрөө.

Мэдээлэл авах, лавлах утас: 328030-210, 99125492, 328030-612, 91994262

Орон нутгаас оролцох эрүүл мэндийн байгууллагууд харьяа нийгмийн даатгалын хэлтэст материалаа 2014 оны 8 дугаар сарын 1-ний дотор өгнө үү.

Материал хүлээн авах эцсийн хугацаа: 2014 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн 17 цаг.